



# СОЙМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№204 /414/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.11

Цаг үе, үйл явдал

## Г.БОЛОР: ЦЭРГИЙН СУРГАЛТ, СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫГ ХАНГАХАД ОНЦГОЙ АНХААРЧ БАЙНА



ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын 100 жилийн ойн хүрээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд харилцан туршлага солилцох, цаашдын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой "Сэтгэл зүй ба бидний манлайлал" сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулж байна.

Уулзалтад ЗХЖШ-ын СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалууд, БИЦУГ, ХХЕГ, Дотоодын цэрэг, ОБЕГ, ШШГЕГ, ЦЕГ болон тэдгээрийн харьяа нэгтгэл, анги, салбаруудын сэтгэл зүйн асуудал хариуцсан нэгж, албан тушаалтнууд оролцоо.

Чуулга уулзалтыг нээж ЗХЖШ-ын СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор хэлсэн үгэндээ

"Улс орны нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, бие бүрэлдэхүүний ажлын ачаалал, гэр бүлийн зөрчилдөөнт харилцаа, нийгмийн хамгааллын харилцан адилгүй байдал зэрэг тулгамдсан асуудлаас шалтгаалан цэргийн алба хаагчдын дунд стресс, бухимдал, сэтгэл санааны тогтворгүй байдал бий болж, гэмт хэрэг, сахилгын зөрчил гаргах, албаны үйл ажиллагаа доголдох үндэс суурь болж байна. Иймд цэргийн сургалт, бэлтгэлийн чанар, үр дүнг дээшлүүлэх, удирдах албан тушаалтнуудын сэтгэлгээ, хүнтэй ажиллах арга барилыг сайжруулах зорилгоор Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний цугларалтыг "Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний манлайлал, цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх нь" сэдвээр зохион байгуулж, манлайллын дүрэм, номлол

боловсруулах ажлыг эхлүүлэн, Зэвсэгт хүчний 2022-2023 оны сургуулийн жилийг "Залуу офицеруудын манлайллын жил болгон зарлаж, цэргийн сургалт, сэтгэл зүйн бэлтгэлийн харилцан хамаарлыг хангахад онцгой анхааран ажиллаж байна" гэсэн юм.

Мөн тус чуулга уулзалтын үеэр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд сэтгэл зүйн чиглэлээр боловсруулан гаргасан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа эрх зүйн баримт бичгүүд, дүрэм, журам, заавар болон ном, гарын авлагуудаар үзэсгэлэн дэлгэсэн нь харилцан туршлага, сургамж, мэдээлэл солилцох чухал ач холбогдолтой гэдгийг холбогдох албаны хүмүүс онцоллоо.

Ө.НАСАНТОГТОХ

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-17

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,425	3,428
EUR	3,460	3,490
CNY	473	476
RUB	53.10	53.70
JPY	23.95	24.40
KRW	2.55	2.59

### ЗУРХАЙ

2022.11.11 / БААСАН ГАРГАГ  
БИЛГИЙН ТООЛЛЫН 17

**НАМРЫН АДАГ ЦАГААН  
НОХОЙ САР  
ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАР  
ЛУУ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд МАЛЫН ГАРЛАГАТАЙ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.52-17.20

Барилдлага:

Үл тохирох  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Хурьцахуй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

## АРХИВЫН ТАВАН ТӨРЛИЙН ЛАВЛАГААГ "E-MONGOLIA" СИСТЕМД НЭВТРҮҮЛЛЭЭ

**БАТЛАН ХАМГААЛАХЫН ТӨВ АРХИВ**

**ДАЙНД ОРОЛЦСОН**  
АХМАД ДАЙЧДЫН ЛАВЛАГАА

**ХУГАЦААТ ЦЭРГИЙН**  
АЛБА ХААСАН ЛАВЛАГАА

**АЖИЛЛАСАН ЖИЛИЙН**  
ЛАВЛАГАА

**ЦАЛИНГИЙН**  
ТОДОРХОЙЛОЛТ

**ШИНЭ**  
ҮЙЛЧИЛГЭЭ

ЦАХИМААР ШИЙДЬЕ...

Батлан хамгаалахын төв архиваас иргэд, албан байгууллагын эрэл, хүсэлтийг хүлээн авахдаа биечлэн болон өргөдлөөр гэсэн хоёр хэлбэрээр хүлээн авч үйлчилгээ үзүүлдэг байсан бол одоо "E-mongolia" системийн веб суурьт үйлчилгээгээр дамжуулан тус архивын таван төрлийн лавлагааг цахим хэлбэрээр хүлээн авах боломжтой боллоо. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх зорилгоор хэвлэлийн бага хурлыг зохион байгуулав.

Тус архиваас Ардын цэрэг, Монголын Ардын Армийн Зэвсэгт хүчинд 1951-2018 онд хугацаат цэргийн алба хаасан, БХЯ, ЗХЖШ, харьяа командлал, анги, байгууллагуудад хөдөлмөр эрхэлсэн, цалинжсан, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн, 1940-1948 онд улсын баруун хилд болсон зэвсэгт мөргөлдөөний үед цэргийн алба хааж, дайн байлдаанд оролцсон ахмад дайчдын тухай болон цол шагнагдсан, албан тушаалд томилогдсон, сургуульд элссэн, төгссөн тушаал, дүнгийн хүснэгтийн хуулбар зэрэг лавлагаа, үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем "E-mongolia.mn" сайтаар дамжуулан авах боломж бүрдэж байна. Ингэснээр иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэх давуу талтайг хэвлэлийн бага хурлын үеэр онцолж байсан юм.

Энэ үеэр Батлан хамгаалахын төв архивын дарга дэд хурандаа Ж.Гантулга "Жилд дунджаар 11-15 мянган хүн Батлан хамгаалахын төв архиваас лавлагаа, тодорхойлолт авдаг гэсэн тоо баримт бий. Тэр болгонд бид иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйлчилгээ үзүүлдэг. Харин архивын үйлчилгээг цахимжуулснаар тэдгээр үйлчлүүлэгчдэд цаг хугацаа, эдийн засгийн давуу талыг олгож буй юм. Ялангуяа хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг иргэд, албан байгууллагууд цахим системийг ашиглаж бидэнд хүсэлтээ ирүүлснээр заавал Улаанбаатар хотыг зорихгүйгээр үйлчилгээг авах боломжтой гэсэн үг" гэлээ.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 638,843,596

Эдгэрсэн

Нийт: 618,553,439

Нас барсан

Нийт: 6,609,952

Цахим шууданд

## ШИНЭ ДАЙЧИД БУУДЛАГЫН АНХНЫ ДАСГАЛ БОЛОВСРУУЛЛАА



### Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Ангийн 2022-2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, сэтгэл зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх, албад салбаруудын харилцан ажиллагааг хангах зорилгоор энэ сарын 9-ний өдөр офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид гар буу, автоматын нэгдүгээр дасгал, хугацаат цэргийн алба хаагчид буудлагын анхны дасгал боловсрууллаа. Ангийн захирагч, штабын томилгоот бүрэлдэхүүн, сургалтын төвд ажиллаж буй офицер, ахлагч нар буудлагын явцад хяналт тавьж, аюулгүй ажиллагааг онцгой анхаарч ажилласан юм.

Ахлах ахлагч Н.УУГАНЦЭЦЭГ

## ДЭЛХИЙН ХОШОЙ АВАРГА ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Турк Улсын Анталия хотод 10 дугаар сарын 31-ний өдрөөс энэ сарын 7-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Тулааны урлагийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай явагдлаа.

Уг тэмцээний насанд хүрэгчдийн ангилалд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн салааны захирагч дэслэгч Б.Наадам алтан медаль хүртэж дэлхийн хошой аварга болов.

Тэрээр өнөөдөр эх орондоо ирсэн бөгөөд түүнийг "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудалд Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн штабын дарга хошууч генерал Л.Гансэлэм тэргүүтэй төлөөлөгчид, гэр бүл, анд нөхөд нь угтсан юм.

Хошууч Ц.ПҮРЭВДОРЖ

## АНГИЙН МЭРГЭЖЛИЙН АВАРГА ОФИЦЕР, АХЛАГЧААР...



### Зэвсэгт хүчний 303 дугаар анги

ЗХЖШ-аас 2023 оныг "Залуу офицерыг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Агаарын цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах зорилгоор "Ангийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнийг зохион байгуулаа.

Тэмцээнд оролцогчид удирдамжийн дагуу мэргэжлийн бэлтгэл, ҮОХЗ, галын бэлтгэл, тактикийн бэлтгэл, авто техникийн бэлтгэлийн дасгал, нормативуудыг гүйцэтгэлээ. Тэмцээний



тэргүүн байрт офицеруудаас ахлах дэслэгч М.Төрболд, дэд байрт ахлах дэслэгч М.Бат-Эрдэнэ, ахлагч нараас тэргүүн байрт ахлагч Б.Ган-Эрдэнэ, дэд байрт ахлагч У.Эрдэнэбаяр нар шалгарч бусад нөхдөө манлайлав.

Тэмцээнд оролцсон нийт бүрэлдэхүүнд ангийн захирагч хурандаа Д.Шатаррагчаа баяр хүргэхийн зэрэгцээ Агаарын цэргийн мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнд бэлтгэлээ сайн хангаж, амжилттай оролцохыг үүрэг болгосон юм.

## “ХУРДАЧ РАДИСТ”-ИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТ БОЛОВ



Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагддаг "Хурдач радист"-ын тэмцээн энэ удаа Монгол Улсын баруун бүсийн Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги, байгууллагуудын дунд зохион байгуулагдахаар бэлтгэл ажлаа хангаад

байна. Энэ удаагийн тэмцээнийг Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Монголын радио-спортын холбоотой хамтран зохион байгуулж буй бөгөөд өчигдөр тэмцээний нээлтийг зохион байгууллаа.


Тус арга хэмжээнд Зэвсэгт хүчний

325 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Э.Энхбаяр, Монголын радио-спортын холбооны удирдах зөвлөлийн гишүүн радио-спортын ОУХМ, улсын шүүгч бэлтгэл хошууч Ч.Чинбат, Радио-спортын ОУХМ, улсын шүүгч хошууч Б.Мөнгөнзул, сургагч ахлагч Ц.Болдбаатар нар оролцов.

Уг тэмцээний зорилго нь мэргэжлийн радио телеграфчдын ур чадварыг үнэлэх, мэргэжлийн зэрэгтнийг нэмэгдүүлэх болон радио спортын өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэхэд оршиж буй юм. Тус спортын тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар анги болон тусгай салбарууд, 123 дугаар анги, 331 дүгээр уулын тусгай батальон, Хилийн цэргийн 0214 болон 0257 дугаар отрядуудын нийт 13 багийн 62 тамирчин хурд, хүч, авьяас чадвараа сорих бөгөөд алслагдсан анги, салбарууд онлайнгаар оролцох нөхцөлийг бүрдүүлж өгснөөрөө онцлог аж.

Б.ХАТАНБААТАР

## БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ч.ЦОГТЖАРГАЛ ДОРНОД АЙМАГТ АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Ч.Цогтжаргал 11 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангид ажиллаж байна.

Хуурай замын цэргийн командлагчийг тус ангийн бие бүрэлдэхүүн Байлдааны тугтай угтан авсны дараа танилцуулга сонсож, зарим цэргийн байруудад ажиллаж, Зэвсэгт хүчний 338 дугаар ангийнхны гүйцэтгэл буй цэргийн гал тогооны барилгын явц, Сургалтын төвтэй танилцав.



Мөн тэрээр Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабт ажиллаж, орон нутаг дахь төрийн цэргийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүүхэд залууст цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлын явц, бусад хамтын ажиллагааны талаар ярилцаж, ангийн бие бүрэлдэхүүнтэй уулзаж ярилцлаа.

Уулзалтаар салбарын эрх зүйн орчин, цэргийн сургалт бэлтгэлийн шинэчлэл, алба хаагчдын манлайлал, идэвх оролцоо, бие бялдрын бэлтгэлжилт, ёс зүй, сахилга хариуцлага, нийгмийн хамгаалал зэрэг олон сэдвээр ярилцав.

## ЗЭРЭГ, БҮСНИЙ ШАТЛАЛАА АХИУЛЛАА



ЦДБЭЧ-ын хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн "Хөгжим эмчилгээ"-ний хөтөлбөрт нэгдэж мэргэжлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласаар байна.

Эмнэлгийн орчинд эерэг тааламжтай уур амьсгалыг бүрдүүлэх, өвчтөн, үйлчлүүлэгчдийг сэтгэл зүйн хувьд тайвшруулах, эмчилгээний үр нөлөөг хөгжим, урлагийн бүтээлээр дэмжих зорилго бүхий "Хөгжим эмчилгээ"-ний өдөрлөгийн хүрээнд ЦДБЭЧ-ын үндэсний хөгжмийн цөөхүүл бүрэлдэхүүн шилдэг бүтээлүүдээсээ бүрдсэн тоглолтыг зохион байгууллаа.